



**МОНГОЛ УЛС: 2024-2028 ОНД АЖИЛЛАХ
УЛСЫН ИХ ХУРАЛД САНАЛ БОЛГОХ
ХҮНИЙ ЭРХИЙН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



Эмнести Интернэшнл нь хүн бүрт эрхийг нь
эдлүүлэхийн төлөө хүмүүсийн хүнлэг сэтгэлд
тулгуурлан кампанит ажил өрнүүлдэг 10 сая
хүнийг эгнээндээ нэгтгэсэн дэлхий даяарх хүний
эрх хамгаалагчдын хөдөлгөөн юм. Эрх баригчид
олон улсын эрх зүй, хэм хэмжээг хүндэтгэдэг,
хариуцлагаа хүлээдэг, амлалтдаа хүрдэг дэлхий
ертөнцийг бий болгохын төлөө бид ажилладаг.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл суртал,
эдийн засгийн ашиг сонирхол, шашин шүтлэгээс
ангид бие даасан, хараат бус бөгөөд гишүүд,
дэмжигчдийнхээ хандив тусламжаар санхүүждэг.

Хүмүүс эв санааны нэгдэлтэй, хүмүүнлэг энэрэнгүй
байснаар илүү сайхан нийгмийг бий болгож,
өөрчилж чадна гэдэгт бид итгэдэг.

©Эмнести Интернэшнл 2024

Энэ товхимол дахь контент Креатив Коммонс-оор зөвшөөрөгдсөн
(жинхэнэ эх хувь нь, худалдааны бус, хуулбарлаагүй, олон улсын 4.0)
лицензийн дагуу баталгаажсан болно.
<https://creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode>
Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл манай: www.amnesty.org цахим
хуудасны зөвшөөрөл хэсгээр зочлоорой.

Монгол улс, Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж, 6-р хороо, #AB
төвийн 7 давхарт 701 тоот, Монголын Эмнести Интернэшнлийн байр,
анхны хэвлэл, 2024 он.

Index: ASA 30/7966/2024

Эх хэл: Монгол хэл

amnesty.org



Нүүр зураг: Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн төлөөх
«Төр үүргээ мэд, биелүүл» кампанит ажлын нээлт.
Д.Сүхбаатарын талбай, Улаанбаатар хот, Монгол улс.
Зургийг © Монголын Эмнести Интернэшнл

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА	5
ХОТ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД ХҮНИЙ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭН ХАМГААЛАХ	6
БАЙГАЛЬ ОРЧНЫ ДОРОЙТЛООС ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ	8
ШУДАРГА БУС ТАТВАР, ТӨСВИЙН ХЭМНЭЛТИЙН БОДЛОГООС ҮҮСЧ БУЙ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫГ АРИЛГАХ	9
ТЕХНОЛОГИОС ҮҮДЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛД АНХААРАХ	10
ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ, ТАЙВАН ХУРАН ЦУГЛАХ ЭРХИЙГ ХАМГААЛАХ	12
ЯЛ ЗАВШИХ ЯВДЛЫГ ТӨГСГӨЛ БОЛГОХ	14

ТАЙЛБАР

НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ЭДХ	Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлэг
ХЭХ	Хүний эрх хамгаалагч
УИХ	Улсын Их Хурал
ИУТЭОУП	Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
ЭЗНСЭОУП	Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн тухай олон улсын пакт
ГХДБГ	Гэр хорооллын дэд бүтцийн газар
ЭЗТХҮГ	Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ

ТАНИЛЦУУЛГА

2024-2028 ОНД АЖИЛЛАХ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД САНАЛ БОЛГОХ ХҮНИЙ ЭРХИЙН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

Монгол улс 2020 онд Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлэг (ЭДХ)-ээр орж, 190 зөвлөмжөөс 170-ыг нь хүлээн авсан¹.

Эдгээр зөвлөмжид хүний эрх, байгаль орчин, сайн засаглал, авлигатай тэмцэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө зэрэг сэдвүүд багтсан. Мөн Эмнести Интернэшнлийн санал болгосон хүний эрх хамгаалагч (ХЭХ)-ийг хамгаалсан хууль батлах, эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцсан талаарх гомдлыг шуурхай, үр дүнтэй шалгах хараат бус, бие даасан механизм байгуулж, гэмт этгээдүүдэд хариуцлага тооцохыг баталгаажуулах тухай зөвлөмжүүд орсон².

2020-2024 онд ажилласан Монгол Улсын Их Хурал (УИХ) ЭДХ-ийн эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд хууль, бодлого санаачлах, батлах, хэрэгжүүлэх тал дээр тодорхой ахиц дэвшил гаргасан³. Тухайлбал, Монгол Улс 2021 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан Ази тивийн анхны улс болсон⁴. 2022 оны 6 дугаар сард УИХ-аас Хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан Хүний Эрхийн Үндэсний Комиссын гишүүнийг томилж⁵, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх механизм байгуулагдсан. Мөн 2022 оны 6 дугаар сард Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн дагуу Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг⁶ байгуулсан.

Гэвч 2020-2024 онд ажилласан УИХ эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцсан тухай гомдлыг үр дүнтэй шалгах бие даасан механизмыг байгуулах талаар зохих, үр дүнтэй арга хэмжээ авсангүй. Мөн хот дахин төлөвлөх ажлын хүрээнд шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг баталгаажуулж чадаагүй, байгаль орчны асуудлаарх хүний эрхийн зөрчил, албадан нүүлгэлтийн талаарх асуудлыг зохистойгоор шийдвэрлэсэнгүй. Бүх насаар нь хорих ял эдэлж буй хоригдлуудын бие махбод, сэтгэцийн эрүүл мэндэд

¹ UN Report of the Working Group on the Universal Periodic Review (WG UPR) Addendum, Report: Mongolia, 22 February 2021, UN Doc. A/HRC/46/9/Add.1, paras 1-4.

² Монголын Эмнести Интернэшнл, Монгол улс Хүний эрхийн нөхцөл байдлаа сайжруулахын тулд илүү ихийг хийх ёстой, НҮБ-ын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт Эмнести Интернэшнлээс илгээх мэдээлэл, ЭДХ-ийн ажлын хэсгийн 36 дугаар хуралдаан, (ASA 30/1297/2019) <https://www.amnesty.org/en/documents/asa30/1297/2019/en/>

³ «Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаанд Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын хэлсэн үг, 2023, <https://www.parliament.mn/nn/51485/>

⁴ Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/translate/>

⁵ Монгол Улсын Их Хурлын 28-р тогтоол, Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн томилох тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530492196621>

⁶ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, 2020, <https://legalinfo.mn/mn/detail/15152>

анхаарал хандуулсангүй⁷.

Иймд Монгол Улс иргэдийнхээ хүний эрхийн хамгаалалт, биелэлтийг сайжруулахын тулд Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрөө шинэчлэн боловсруулах шаардлагатай байна⁸. Ялангуяа Монгол Улс Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ЭЗНСЭОУП)-ыг зохистой хэрэгжүүлэх, корпорацийн оролцогчдын зүгээс шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрх, байгаль орчны асуудал, технологитой холбоотой хүний эрхийн зөрчил зэрэг эдийн засаг, нийгэм, соёлын эрхэд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг таслан зогсоох чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авах ёстой⁹.

Эмнести Интернэшнлээс Монгол Улсын Их Хурлын гишүүдийг үндэсний хүний эрхийн үзүүлэлтээ сайжруулах, төрөөс хүний эрхийг зөрчихгүй байх, өмнө нь зөрчигдсөн эрхүүдийг сэргээх арга хэмжээ авахаа баталгаажуулахыг энэхүү баримт бичгээр уриалж байна.

Эмнести Интернэшнлээс УИХ-ын шинээр сонгогдсон гишүүдийг цаашид Монгол Улсын эдийн засаг, нийгэм, соёлын эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван хуран цуглах эрх, эрүү шүүлт болон бусад зүй бус харьцаанаас ангид байх, шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаажуулах амлалтынхаа нэг хэсэг болгож энэ товчлолд дурдагдсан 6 зүйлт асуудалд анхаарч ажиллахыг уриалж байна.

ХОТ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД ХҮНИЙ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭН ХАМГААЛАХ

Улаанбаатар хотод дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжээд багагүй хугацаа өнгөрсөн ч хууль, эрх зүйн орчны хийдэл, хэрэгжилтийн хангалтгүй байдал, холбогдох төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоогүй, хариуцлагагүй байдлын улмаас дахин төлөвлөлтөд хамрагдсан иргэдийн эрх зөрчигдсөөр байна¹⁰. Түүнчлэн Дахин төлөвлөлтийн талаарх шинэчлэгдсэн мэдээллээр хангагдахгүй, дахин төлөвлөлтийн улмаас нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүст зохих нөхөн олговор олгогдохгүй, нөлөөлөлд өртсөн хүмүүстэй бодитоор зөвлөлдөхгүй байгаагаас үүдэн оршин суугчид албадан нүүлгэгдэх¹¹, орон гэргүй болох эрсдэл дунд амьдарч байна.

Газар чөлөөлөлт, шударга нөхөн олговор олгох, албадан нүүлгэлт, зөрчигдсөн эрхийг сэргээх асуудлыг зохицуулах Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль¹² (2023), Хот байгуулалтын тухай

⁷ Монголын Эмнести Интернэшнл, «Хүний Эрхийн Үндэсний Форум-2023» -ын илтгэл, <https://amnesty.mn/news/123>

⁸ Монгол Улсын их хурлын 41-р тогтоол, Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай, <https://legalinfo.mn/mn/detail/6265>

⁹ UN, Report of the Special Rapporteur on the issue of human rights obligation to the enjoyment of a safe, clean, healthy, and sustainable environment on his mission to Mongolia, 02 May 2018, UN. Doc A/HRC/37/58 add.2.

¹⁰ Amnesty International, «Mongolia: Thousands at risk of homelessness due to authorities' urban redevelopment failings», 07 December, 2016, <https://www.amnesty.org/en/latest/news/2016/12/mongolian-authorities-are-failing-residents-of-ulaanbaatar-redevelopment-2/>

¹¹ Монголын Эмнести Интернэшнл, Монгол улс Хүний эрхийн нөхцөл байдлаа сайжруулахын тулд илүү ихийг хийх ёстой, НҮБ-ын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт Эмнести Интернэшнлээс илгээх мэдээлэл, ЭДХ-ийн ажлын хэсгийн 36 дугаар хуралдаан, (ASA 30/1297/2019), 2020 оны 11 дүгээр сар, ху.8.

¹² Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, 2023, <https://legalinfo.mn/mn/detail?law-id=16960742235481>

хууль¹³ (2008) болон Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулиуд¹⁴ (2015) нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд, тэр дундаа шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн хэм хэмжээнд нийцэхгүй байна.

Гуравдагч этгээдийн зүгээс иргэдийн орон байрны халдашгүй байдалд халдахаас хамгаалсан эрх зүйн орчин, бодлогын шийдэл дутмаг байгаагийн дээр гомдол гаргах журам, маргаан шийдвэрлэхтэй холбоотой тайлбар тодорхой бус байсаар байна¹⁵.

Ялангуяа хот дахин төлөвлөлтийн нөлөөлөлд өртсөн иргэд баригдсан барилга байгууламжийн чанар, стандарттай холбогдуулан гомдол гаргах, учирсан хохирлоо шударгаар нөхөн төлүүлэх, зөрчигдсэн эрхээ хамгаалуулахад хүндрэлтэй байна.

Монголын Эмнести Интернэшлээс 2020-2024 оны УИХ-д хот дахин төлөвлөлттэй холбоотой зөвлөмж¹⁶ хүргүүлсэн ч өнөөг хүртэл хэрэгжүүлээгүйд гүнээ харамсаж байна.

ЗӨВЛӨМЖ:

1. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай, Хот байгуулалтын тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулиуд болон бусад хууль тогтоомжид олон улсын хүний эрхийн хуулиар хамгаалагдсан орон байраар хангагдах эрхийн хамгаалалтыг цогцоор нь тусгаж, шинэчлэн батлах.
2. Эдгээр хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, уялдааг сайжруулж, хот дахин төлөвлөх, процесс процедурыг хянах, хариуцлага тооцох механизмыг бий болгох.
3. Дахин төлөвлөлтийн хүрээнд иргэдийг албадан нүүлгэх, хүч хэрэглэх байдлыг хориглож, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн өмнө заавал дагаж мөрдөх хамгаалалтын арга хэмжээ авах эрх зүйн зохицуулалтыг бий болгох.
4. Иргэдийн орон байраар хангагдах эрх ноцтой зөрчигдөж, орон гэргүй болсон сөрөг үр дагаврыг арилгаж, тухайн иргэдийг хохиролгүй болгох, хөндөгдсөн эрхийг сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ДОРОЙТЛООС ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ

Эрх баригчид цэвэр ус, газар, бэлчээр ашиглах, эзэмших болон уламжлалт өв соёл, амьжиргаанд нь сөрөг нөлөө үзүүлж байгаа уул уурхайн компаниудын үйл ажиллагаанаас малчдыг хамгаалж чадахгүй байна. Түүнчлэн байгалийн давагдашгүй хүчин зүйл, уур

¹³ Хот байгуулалтын тухай хууль, 2008, <https://legalinfo.mn/mn/detail/530>

¹⁴ Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, 2015, <https://legalinfo.mn/mn/detail/11219>

¹⁵ Эмнести Интернэшнл, Хангалтгүй хэрэгжүүлж байгаа нь, Монгол улсын нийслэл Улаанбаатар хот: Орон байртай байх эрх, (Index: ASA 30/4933/2016), 2016, <https://www.amnesty.org/en/documents/asa30/4933/2016/mn/>, ху.15.

¹⁶ Монголын Эмнести Интернэшнл, Монгол улс: 2020-2024 онд ажиллах Улсын Их Хуралд санал болгох хүний эрхийн хэлэлцэх асуудал, 2020 <https://amnesty.mn/library/3622>

амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс иргэдийг хамгаалах, тэдний хохирлыг бүрэн барагдуулж зөрчигдсөн эрхийг сэргээх, гамшгийн үе дэх хүний эрхийн асуудалд анхаарал хандуулж чадахгүй байна¹⁷.

Иргэд амьдардаг суурьшлын бүсэд уул уурхайн компани хортой хог хаягдал хаясны улмаас иргэд хордсон тухай болон хортой хог, бохирдлын талаарх мэдээллийг олон нийтэд ил болгуулахгүй хэмээн уул уурхайн компаниуд малчдыг айлган сүрдүүлж буй талаарх гомдлууд Эмнести Интернэшнлд ирсэн¹⁸.

2018 онд Монгол улсын засгийн газар улс орон даяар бизнесийн үйл ажиллагааг хянах чиг үүрэг бүхий Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгах шийдвэр гаргасан¹⁹. Хэдийгээр засгийн газрын тогтоолоор Мэргэжлийн хяналтын чиг үүргийг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд шилжүүлсэн²⁰ боловч энэ шийдвэр нь уул уурхайн компаниудын нөлөөллийг бууруулах, оршин суугчдын эрхийг хамгаалах төрийн үүргийг биелүүлэхэд сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй.

ЗӨВЛӨМЖ:

1. Хорт бодисын хадгалалт, хамгаалалт, устгалд хяналт тавих тогтолцоог цогцоор нь сайжруулах.
2. Хорт бодисын улмаас эд хөрөнгө, эрүүл мэндээрээ хохирсон иргэд мөн байгаль орчин, соёл, нүүдэлчин амьдралын хэв маягаа хадгалан хамгаалахын төлөө тэмцэж буй малчин, нутгийн иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, шударга нөхөх олговор олгох хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хохирлоо үр дүнтэй нөхөн төлүүлэх эрх зүйн орчин бий болгох.
3. Төрийн байгууллагууд хүний эрх, байгаль орчныг хамгаалахад хүндэтгэлтэй хандаж, корпорацийн үйл ажиллагаа, үйлчилгээ, бүтээгдэхүүнд хүний эрх, байгаль орчны хяналтыг тогтмол хэрэгжүүлэх.
4. Монгол Улсын Засгийн газрын “Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)” зэрэг хүний эрхийн тогтоомжуудыг компаниуд дагаж мөрдөж байгаа эсэхийг хянах, компаний явуулж буй үйл ажиллагааны хүний эрх, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлэх тогтолцоог бий болгох хууль батлах.

¹⁷ Эмнести Интернэшнл, Дэлхийн хүний эрхийн төлөв байдлын тайлан, (POL 10/5670/2023) <https://www.amnesty.org/en/documents/pol10/5670/2023/en/> ху.256.

¹⁸ Монголын Эмнести Интернэшнл, Монгол улс Хүний эрхийн нөхцөл байдлаа сайжруулахын тулд илүү ихийг хийх ёстой, ху.8.

¹⁹ Засгийн Газрын 461-р тогтоол, Засгийн Газрын 461-р тогтоол, Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532027305321>

²⁰ Засгийн Газрын 469-р тогтоол, Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2022, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532259091861>

ШУДАРГА БУС ТАТВАР, ТӨСВИЙН ХЭМНЭЛТИЙН БОДЛОГООС ҮҮСЧ БҮЙ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫГ АРИЛГАХ

Монгол улсын нэгдэн орсон ЭЗНСЭОУП-д: “Энэхүү Пактад оролцогч улс бүр дангаараа болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар, тухайлбал эдийн засаг, техникийн салбарт, энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг дэвшилттэйгээр хангахын тулд хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, зохистой арга хэмжээг байгаа бүх боломжийнхоо хэрээр авах үүрэгтэй”²¹ гэж заасан байдаг.

Татварын бодлого нь улс орнуудын хүний эрхийг хүндэтгэх, хамгаалахад шаардагдах нөөцийн ихэнх хувийг бүрдүүлдэг тул²² Монгол улс дотоодын татварын бодлого нь хүний эрхийг хангах, нийгэм эдийн засгийн тэгш бус байдлыг бууруулахад чиглэж хэрэгжих тал дээр хяналт тавих ёстой. Төрийн бүхий л үйл ажиллагаанд хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх үүргийг мөрддөгийн адил татвар болон төсвийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд ч энэ үүргийг мөрдөх ёстой²³.

Татвар, төсвийн зарлагатай холбоотой шийдвэр гаргах үйл явц нь ил тод байх ёстой бөгөөд аль болох бүх нийтийн хэлэлцүүлгийг хийх ёстой²⁴. Тус нийтийн хэлэлцүүлэгт иргэний нийгэм, бодлогод шууд өртөх хүмүүс, тэр дундаа ядууралд өртөх хүмүүсийн үр дүнтэй, утга учиртай оролцоог хангах ёстой.²⁵ 2020-2024 оны УИХ Төсвийн тухай хуулийг шинэчлэн найруулж, төсвийн төслийг боловсруулахад олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах тухай заалтыг нэмсэн нь хүний эрхэд ээлтэй төсвийн зарчмыг хангасан нэмэлт байв²⁶.

ЗӨВЛӨМЖ:

1. Татварын бодлого, улсын төсвийн хувиарлалт зэрэг төсвийн талаарх бүхий л шийдвэрт хүний эрхийн шалгуураар үнэлэлт хийх, хяналт тавих, дотоод чадавхиа нэмэгдүүлэх.
2. Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээг татвар, төсөв бүрдүүлэлт зэрэг төсвийн бодлогын шийдвэр гаргах бүх үе шатад тусгах.

²¹ Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн тухай олон улсын пакт, II хэсэг, 2-р зүйл.

²² Amnesty International, Taxation and Human Rights: A Set of High-Level Principles 2022, (IOR 40/5771/2022), <https://www.amnesty.org/en/wp-content/uploads/2022/06/IO4057712022ENGLISH.pdf>, ху.3.

²³ Amnesty International, Taxation and Human Rights: A Set of High-Level Principles ху.2.

²⁴ UN Independent Expert on the question of human rights and extreme poverty, Magdalena Sepúlveda Carmona, Mission to Ireland, –17 March 2011, UN Doc. A/HRC/17/34, para. 36-38.

²⁵ UN Independent Expert on the question of human rights and extreme poverty, Mission to Ireland, para 36-38.

²⁶ Төсвийн тухай хуулийн 28.2.1 хэсгийн нэмэлт өөрчлөлт.

ТЕХНОЛОГИОС ҮҮДЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛД АНХААРАХ

Технологийн дэвшил нь хүний эрхийн нөхцлийг сайжруулах боломж бүрдүүлж байгаа ч нөгөөтэйгүүр тэгш бус байдлыг гааруулах, шүүмжлэлт дуу хоолойг нухчин дарах, төрөөс тандах программыг ашиглах нь хэвийн үзэгдэл болгох зэрэг эрсдэлтэйг Эмнести Интернэшнл баримтжуулсан.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассамблейн 71-р чуулганы тогтоолд “Хууль бусаар буюу дур зоргоороо бусдын харилцаа холбоог тандаж, хувийн цуглуулах нь хувийн халдашгүй байх эрхийг зөрчсөн үйлдэл бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд саад учруулж болзошгүй”²⁷ тухай дурьдаж, мөн НҮБ-ын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг түгээх, хамгаалах асуудал хариуцсан тусгай илтгэгч “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад (ИУТЭОУП) оролцогч улсууд дижитал харилцаа холбоог тандах нь олон улсын хэм хэмжээ, НҮБ-ын тусгай илтгэгчийн зөвлөмж зэрэг зөвлөмжүүдийн дагуу байх ёстой ба үүнийг баталгаажуулахад шаардлагатай хууль тогтоомжийн болон бусад арга хэмжээг авах ёстой”²⁸ болохыг тэмдэглэжээ.

2023 оны 1 дүгээр сарын 20-нд УИХ-аас “Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль”-ийг олон нийтээр хэлэлцэлгүйгээр баталсан²⁹. Гэвч уг хууль нь Үндсэн хууль болон Хууль тогтоомжийн тухай хуулийг зөрчсөн гэж үзэж Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хориг тавьсан. Уг хуулиар “үндэсний эв нэгдэл”, “төрийн нууц”-ыг хамгаалах нэрийн дор шүүхийн хяналт, оролцоогүйгээр олон нийтийн сүлжээн дэх контент, цахим хаягийг хянах, устгах, түдгэлзүүлэх эрх мэдлийг Засгийн газарт олгосон нь цахим орчин дахь үзэл бодлоо илэрхийлэх эрх, шүүмжлэлт дуу хоолойг хязгаарлах эрсдэлийг дагуулахаар байв³⁰.

Засгийн газрууд нийгмийн хамгааллын системдээ дижитал технологийг өргөн хүрээнд хяналтгүйгээр нэвтрүүлж байгаа нь одоо байгаа дутагдал, ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдлыг улам бүр хурцатгаж, хүний эрхийн нөхцөл байдлыг дордуулж болзошгүй³¹. Иймд цахим шилжилт буюу төрийн үйлчилгээг цахимд шилжүүлэх үйл явцад хүний эрхийн асуудалд онцгой анхаарч хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна.

Төхөөрөмж дээрх өгөгдөлд хязгаарлалтгүйгээр хандах боломжтой³², одоогоор бие даасан хөндлөнгийн хяналт тавих боломжгүй өндөр түвшний тандах програм болох Предатор тагнах системтэй холбоотой сүүлийн үеийн техникийн дэд бүтцэд Эмнести Интернэшнлээс хийсэн дүн шинжилгээ Монгол зэрэг улсуудад Предатор программын хэрэглэгч байгааг эсвэл эдгээр улс оронд хувь хүмүүсийг тандаж байж болзошгүйг харуулсан³³.

²⁷ UN, the right to privacy in the digital age: resolution / adopted by the General Assembly, <https://digitallibrary.un.org/record/858023?v=pdf>, xy.3.

²⁸ United Nations, Report of the Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression: Surveillance and human rights, 2019/05/28, xy.8.

²⁹ Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл, [<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16758861629711>]

³⁰ Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл.

³¹ Amnesty International, Global: Governments' adoption of unchecked technologies in social protection system undermines rights, March 2024, <https://www.amnesty.org/en/latest/news/2024/03/global-governments-adoption-of-unchecked-technologies-in-social-protection-systems-undermines-rights/>

³² Эмнести Интернэшнл, Предатор файлууд: Торонд баригдсан нь, <https://amnesty.mn/library/3617>, xy.3.

³³ Эмнести Интернэшнл, Предатор файлууд: Торонд баригдсан нь, xy.4.

ЗӨВЛӨМЖ:

1. Дижитал технологийг олон улсын хүний эрхийн хууль тогтоомж, стандарт, түүний дотор хувийн халдашгүй байх эрх, тэгш эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх байх эрх, түүнчлэн өгөгдөл хамгаалах стандартад нийцүүлэн ашиглахыг баталгаажуулах.
2. Нийгмийн хамгааллын тогтолцоо, засаглал, төрийн үйлчилгээнд аливаа технологийг ашиглахдаа хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлж, тухайн технологийг зохион бүтээхээс эхлээд ашиглах хүртэлх бүх хугацаанд хүний эрхийн үнэлгээ хийж, эрсдэл бууруулах арга хэмжээ авахыг баталгаажуулах.
3. Халдварлах чадвар өндөртэй тагнах программ ашиглах, худалдах, дамжуулахыг хориглох.
4. Цахим тандалтаар дамжуулан хүний эрхийн зөрчил, халдлагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах дотоодын хууль тогтоомжийг сайжруулах, тандалтад өртөж хохирсон хүмүүсийн хохирлыг арилгах арга замыг бий болгоход чиглэсэн хариуцлагын механизм бий болгох.

ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ, ТАЙВАН ХУРАН ЦУГЛАХ ЭРХИЙГ ХАМГААЛАХ

Монгол Улс ИУТЭОУП-ыг соёрхон баталж, Үндсэн хуулийнхаа 16 дугаар зүйлийн 16.16 дах хэсэгт³⁴ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван хуран цуглах эрхтэй байхыг баталгаажуулсан.

Монгол Улс хүний эрхийг хүндэтгэн, хамгаалах үүргээ хэрэгжүүлж, хүмүүс ялгаварлан гадуурхалтаас ангид байж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой байхыг баталгаажуулах ёстой³⁵. Эрх баригчид мөн ташаа мэдээлэл, зар сурталчилгаатай тэмцэх гол хэрэгсэл болох харилцаа холбооны олон талт, чөлөөт, бие даасан байдлыг дэмжих замаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэх таатай орчныг баталгаажуулах ёстой³⁶.

Монголын Эмнести Интернэшнлээс цар тахлын үеийн хууль сахиулах үйл ажиллагаанд мониторинг хийж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхийг зүй бусаар хязгаарласан зэрэг олон улсын хүний эрхийн хууль, хэм

³⁴ Монгол Улсын Үндсэн хууль.

³⁵ Amnesty International, A human rights approach to tackle disinformation: submission to the office of the high commissioner for human rights (Index: IOR 40/5486/2022), 14 April 2022, <https://www.amnesty.org/en/wp-content/uploads/2022/04/IO4054862022ENGLISH.pdf>, xy.14.

³⁶ Joint Declaration on freedom of expression and «fake news», disinformation, and propaganda. UN Special Rapporteur on Freedom of Opinion and Expression, OSCE Representative on Freedom of the Media, Special Rapporteur on Freedom of Expression of the InterAmerican Commission on Human Rights, and the Special Rapporteur on Freedom of Expression and Access to Information of the African Commission on Human and Peoples' Rights (2017), para. 2.a; and Report of the Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression, 23 April 2020, UN Doc. A/HRC/44/49, para 49.

хэмжээг зөрчсөн хууль, бодлого хэрэгжиж байгааг тогтоосон.³⁷ Тус байгууллагаас хууль сахиулагчид тайван жагсаал цуглааныг хууль бусаар тараахын тулд хүч хэрэглэсэн, жагсаал зохион байгуулагчдыг дур зоргоор баривчилж, цагдан хорьсон, шаардлагагүй хүч хэрэглэсэн, хуулиар хамгаалагдсан хүний хувийн мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр задруулсан, ялгаварлан гадуурхсан зэргийг баримтжуулсан³⁸.

Хууль сахиулах байгууллагууд Ковид-19 цар тахал нэрийн дор дур зоргоор баривчлах, цагдан хорихоос эхлээд хууль бусаар хүч хэрэглэх зэргээр нилээдгүй хүний эрхийн зөрчил үйлдсэн. Ялангуяа тайван жагсаал, цуглааныг тараах явцад зохион байгуулагчид, оролцогчидтой хүнлэг бус харьцаж, хүний эрх зөрчсөн³⁹.

Монгол Улс мөн 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 13.14 дүгээр зүйл, 2023 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 21.9 дүгээр зүйлд өөрчлөлт оруулж, олон улсын хууль, хэм хэмжээг зөрчин үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, тэр дундаа цахим болон цахим бус орчин дахь хэвлэлийн эрх чөлөөг хязгаарласан хууль санаачилж, баталж, хэрэгжүүлж байна⁴⁰.

Түүнчлэн эрх баригчдыг шүүмжилсэн гэх, эсвэл шүүмжлэлт үзэл санаагаа илэрхийлсэн сэтгүүлчид болон бусад хүнийг айлган сүрдүүлж, үндэслэлгүйгээр мөрдөн шалгаж, дур зоргоор хорьж, торгууль оногдуулсан⁴¹.

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталснаар Ази тивдээ хүний эрхийн асуудал, зөрчлийн талаар дуугардаг хүмүүсийг хамгаалах тогтолцоог бүрдүүлсэн анхдагч улс болсон. Гэвч тус хууль нь ХЭХ-ийн эрхийг хязгаарлаж болохуйц зарим зүйл заалтыг агуулсан. Үүнд 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсэгт *“Хүний эрх, эрх чөлөө, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаахыг хориглох тухай”* заасан. Энэ өргөн хүрээг хамарсан заалт нь эрх мэдэл бүхий хүмүүсийг олон нийтийн өмнө буруутгасан аливаа үйлдлийг хуулийн хоригийг зөрчсөн хэмээн ХЭХ-ийг дуугүй байлгах, эсвэл гэмт хэрэгтэн болгох зэргээр буруугаар ашиглагдаж болно. Ялангуяа олборлох үйлдвэртэй холбоотой хүний эрхийн зөрчлийн асуудлаар ажиллаж буй хамгаалагчдад тодорхой эрсдэл дагуулна. Үүний нэгэн адил 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх хэсгийн *“гадаад улсын тусгай албад, түүний халхавч байгууллага болон үндэсний эв нэгдлийг бусниулах, мөнгө угаах, террорист болон экстремист үйл ажиллагаа явуулдаг, санхүүжүүлдэг байгууллага, хувь хүнээс, эсхүл хандивлагч нь тодорхойгүй санхүүжилт авахыг хориглосон”* ерөнхий нэр томьёо нь хүний эрх хамгаалагчдад санхүүгийн эх үүсвэр олж авахад саад учруулах зорилгоор ашиглагдаж болзошгүй⁴².

³⁷ Монголын Эмнести Интернэшнл, Ковид 19 цар тахал хууль сахиулах ажиллагаа Монгол Улс: Цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйлдсэн хүний эрхийн зөрчил, тохиолдол, 2021, ху. 5, <https://amnesty.mn/library/3608>.

³⁸ Монголын Эмнести Интернэшнл, Ковид 19 цар тахал хууль сахиулах ажиллагаа Монгол Улс: Цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйлдсэн хүний эрхийн зөрчил, тохиолдол, ху.5

³⁹ Монголын Эмнести Интернэшнл, Ковид 19 цар тахал хууль сахиулах ажиллагаа Монгол Улс: Цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйлдсэн хүний эрхийн зөрчил, тохиолдол, ху.10, пара 1.

⁴⁰ Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл, 2023, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16758861629711>.

⁴¹ Ikon.mn, «Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нухчин дарсан нь», 2021, <https://ikon.mn/opinion/2em4>;

Asuudal.mn, «Монгол дахь үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай», 2023, <http://www.asuudal.mn/more/8131> болон Unuudur.mn «Сэтгүүлчид гартаа гав зүүж, хэвлэлийн эрх чөлөөний төлөө жаргалаа», 2024, <https://www.unuudur.mn/a/267619>

⁴² ISHR, Mongolia adopts region's first HRD Law; some provisions worry defenders, 10 August 2021, <https://ishr.ch/latest-updates/mongolia-concerns-over-restrictive-hrd-law-passed-by-mongolian-parliament/>

Эмнести Интернэшнлээс УИХ-д хандан одоо хэрэгжиж байгаа хууль тогтоомжоо үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван хуран цуглах эрхийн талаарх олон улсын хууль, хэм хэмжээнд нийцүүлэх, тэр дундаа хүний эрхийг зөрчсөн зүйл заалтуудыг хүчингүй болгох, шинээр боловсруулж байгаа хуулийн төслүүд нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн байхыг баталгаажуулахыг шаардаж байна.

ЗӨВЛӨМЖ:

1. “Худал мэдээлэл” эсвэл “ташаа мэдээлэл түгээх” зэрэг тодорхой бус, хоёрдмол утгатай ойлголтод үндэслэн мэдээлэл түгээхэд хориг тавихгүй байх, үүнд Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.14-р зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа хууль тогтоомжийг хүчингүй болгох буюу өөрчлөх.
2. Тайван хуран цуглах эрхийг зүй бусаар, хэт хязгаарласан бодлого, хуулийг хүчингүй болгох. Тайван хуран цуглах эрхийг дэмжих төрийн үүргийг тодорхойлж, Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль болон бусад холбогдох хуулийг олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн шинэчлэн сайжруулах.
3. Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийг олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулах.
4. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд дүн шинжилгээ хийж, хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсгийг өөрчлөх, эсхүл эдгээр заалтыг хязгаартай хэрэгжүүлэх талаар нэмэлт баталгаа, удирдамжаар хангаж, эрх баригчид хүний эрх хамгаалагчдын хууль ёсны үйл ажиллагааг хязгаарлахын тулд эдгээр заалтыг буруугаар ашиглахгүй байхыг баталгаажуулах.

ЯЛ ЗАВШИХ ЯВДЛЫГ ТӨГСГӨЛ БОЛГОХ

Монгол Улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт протоколыг 2014 онд баталсан боловч Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулах тухай тусгасан ХЭҮК-ын тухай хуулийг 2020 онд шинэчлэн баталсан⁴³. Уг механизмыг 2022 оноос ХЭҮК дээр хэрэгжүүлж эхэлсэн нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх чухал алхам болсон⁴⁴.

Эрүүдэн шүүж, зүй бус харьцсан тохиолдлууд бүртгэгдсээр байгаа ч, шүүхээр шийдвэрлэгдэх нь ховор байна. Улсын Ерөнхий Прокурорын газрын тайланд дурдсанаар эрүүдэн шүүж, зүй бус харьцсан гэх гомдлуудын ердөө 5% нь шүүхэд шилжиж байгаа нь Монгол улсад ийм үйлдлийг мөрдөн шалгаж байгаа байгууллагын хараат бус байдал, чадвар дутагдаж байна⁴⁵.

⁴³ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, 2023, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15152>

⁴⁴ Хүний эрхийн Үндэсний Комиссын цахим хуудас, <https://nhrcm.gov.mn/news/57/5>

⁴⁵ Монгол Улсын Прокурорын Ерөнхий Газар, «Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.5 хувиар өссөн байна» 2023, <https://prokuror.mn/post/111337>

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос 2014 онд Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг татан буулгаж, чиг үүргийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэнд санаа зовниж байгаагаа илэрхийлсэн. Дэд хороо төрийн албан хаагчийн эрүүдэн шүүж, зүй бус харьцсан үйлдлийг төрийн албан хаагч өөрсдөө мөрдөн шалгах нь хараат бус, шударга байдал алдагдаж, мөрдөн шалгах ажиллагаа үр дүнтэй байх, улмаар эрүүгийн хэрэг үүсгэх, гомдол гаргах магадлал буурснаар ял шийтгэлгүй үлдэх эрсдлийг нэмэгдүүлж байгаад санаа зовниж байгаагаа мөн илэрхийлсэн⁴⁶.

НҮБ-ын эрүүдэн шүүхийн асуудлаарх Тусгай илтгэгч эрүүдэн шүүсэн эсвэл бусад зүй бус харьцсан тухай гомдлыг нэн даруй шийдвэрлэх, ийм гомдлыг эрүүдэн шүүсэн хэрэгт мөрдөн шалгагдаж, яллагдаж байгаа этгээдээс хараат бус хөндлөнгийн эрх бүхий байгууллагаар шалгуулах, бүтэц, чиг үүргийнхээ хувьд бие даасан мөрдөн шалгах бүрэн эрх бүхий механизмыг хуульд үндэслэн байгуулах нь хууль дээдлэх ёсыг хэрэгжүүлэх, эрүүдэн шүүхтэй тэмцэхэд чухал арга хэрэгсэл хэмээн зөвлөмжилсөн⁴⁷. Эмнести Интернэшнлээс Монгол улсад хандан НҮБ-ын Элжит Дүгнэлт Хэлэлцүүлгийн зөвлөмжийг⁴⁸ бүрэн хэрэгжүүлэхийг уриалж байна.

Монгол Улс 2023 онд Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенц буюу Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ (ЭЗТХҮГ)-г санаачлагч орнуудын нэг болсонд Эмнести Интернэшнл талархаж байна. Энэ гэрээ нь дээрх гэмт хэргүүдийг ялах, хохирогчдын хохирлыг барагдуулах, шударга ёс тогтооход өөрчлөлт авчирах боломж юм⁴⁹.

ЗӨВЛӨМЖ:

1. Хүлээн авсан гомдол мэдээлэл, мөрдөн шалгах ажиллагаа, үр дүнгийн талаар олон нийтэд тогтмол мэдээлэх замаар олон нийтийн хараа хяналт бий болгох, эрүүдэн шүүж, бусад зүй бус харьцсан хэргийг шударга, шуурхай, үр дүнтэй мөрдөх талаарх наад захын олон улсын хэм хэмжээнд нийцсэн байдлаар мөрдөн шалгах чадамжтай, бие даасан эрх бүхий байгууллагыг бий болгох. Мөрдөн шалгах механизм нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмаас тусдаа, ангид байхыг баталгаажуулах.
2. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай дээрх гэрээг нэн даруй, тайлбаргүйгээр соёрхон батлах.

⁴⁶ UN, Report of the Subcommittee, 19 December 2018, UN Doc. CAT/OP/MNG/1.
https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CAT%2FOP%2FMNG%2F1&Lang=en

⁴⁷ UN, Istanbul Protocol: Manual on the Effective Investigation and Documentation of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment (2022 edition), 29 June 2022, <https://www.ohchr.org/en/publications/policy-and-methodological-publications/istanbul-protocol-manual-effective-0>, xy.9, napa 39.

⁴⁸ UN, Human Rights Council, 22 February–19 March 2021, Report of the Working Group on the Universal Periodic Review, <https://documents.un.org/doc/undoc/gen/g20/356/00/pdf/g2035600.pdf?token=KFE1E55jr8Xz0e4lcM&fe=true>

⁴⁹ Ljubljana-The Hague Convention on International Cooperation in the Investigation and Prosecution of the Crime of Genocide, Crimes against Humanity, War Crimes and other International Crimes (adopted on 26 May 2023, not yet entered into force at the time of writing), <https://www.gov.si/assets/ministrstva/MZEZ/projekti/MLA-pobuda/konvencija-dokončna/The-Ljubljana-The-Hague-Convention-Final-English.pdf>, сэдэв 8.

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ НЬ
ХҮНИЙ ЭРХИЙН
ТӨЛӨӨХ ДАЯН
ДЭЛХИЙН
ХӨДӨЛГӨӨН
БӨГӨӨД НЭГ ХҮНД
ТОХИОЛДОХ
ШУДАРГА БУС
ЯВДАЛ Ч БИД
БҮГДЭД ХАМААТАЙ.**

ХОЛБОО БАРИХ



info@amnesty.org



+44 (0)20 7413 5500

+976 7000 4708



<https://www.facebook.com/AIMONGOLIA>



@AmnestyMongolia

МОНГОЛ УЛС: 2024-2028 ОНД АЖИЛЛАХ УЛСЫН ИХ ХУРАЛД САНАЛ БОЛГОХ ХҮНИЙ ЭРХИЙН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

Index: ASA 30/7966/2024

Эх хэл: Монгол хэл

amnesty.org

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ

